

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалт:

“5.1.14. “хамаарал бүхий этгээд” гэж гадаадын иргэний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхдийг;”

2/9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг:

“9.8. Энэ хуулийн 9.2.1-д заасан журам нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал бататгах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зарчмыг баримталж, визийн ангилал, хугацааг тогтоох болон виз олгохтой холбоотой харилцааг зохицуулна.”

3/11 дүгээр зүйлийн 11.8, 11.9, 11.10 дахь хэсэг:

“11.8. Цахим виз олгохтой холбогдох зохицуулалтыг энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-д заасан Монгол Улсын виз олгох журмаар зохицуулна.

11.9. Гадаадын иргэн нь Монгол Улсын виз авах тухай хүсэлтээ Монгол Улсын гадаад улс дахь дипломат төлөөлөгчийн газар, эсхүл Визийн төвд гаргаж болно. Визийн төвийн байршил, түүний ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

11.10. Гадаадын зарим улсын паспорт эзэмшигч иргэнд энэ хуулийн 5.1.12-т заасан визийн зөвшөөрөлгүйгээр олон улсын хилийн боомт дээр “жуулчин” ангиллын, нэг удаагийн, 14 хүртэлх хоногийн хугацаатай, орох визийг олгож болно. Олон улсын хилийн боомт дээр визийн зөвшөөрөлгүйгээр “жуулчин” ангиллын виз олгохтой холбоотой нарийвчилсан журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална”

4/16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсэг:

“16.2. Виз олгох байгууллага нь Монгол Улсын виз олгох журмын дагуу зохих ангиллын визийг олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

16.3. Тухайн ангиллын виз олгоход шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг биедээ авч яваа нөхцөлд, энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу Монгол Улсын хилийн боомт дээр гадаадын иргэнд зохих ангиллын нэг удаагийн орох, дамжин өнгөрөх визийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгож болно.”

5/20¹ дүгээр зүйл:

20¹ дүгээр зүйл. Визийн шаардлагаас чөлөөлөгдөх үндэслэл

20¹.1. Дараахь тохиолдолд гадаадын иргэн Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

20¹.1.1. харилцан визийн шаардлагаас чөлөөлөгдөх талаар тухайн гадаадын иргэний харьяалах улстай гэрээ байгуулсан;

20¹.1.2. Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй;
20¹.1.3. хуульд заасан бусад.”

6/22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг:

“22.2. энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.3. Монгол Улсад ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй, ирсэн зорилгодоо нийцээгүй ангиллын визтэй бол Монгол Улсад оруулахгүй байж болно.”

7/27 дугаар зүйлийн 27.3.5 дахь заалт:

“27.3.5. харьяалах улсын эрх бүхий байгууллагаас гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг хүчингүй болгосон.”

8/27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг:

“27.5. Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын иргэн тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.”

9/32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг:

“32.3. Монгол Улсад албан хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын иргэн тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.”

10/34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт:

“34.2.4. гадаадын иргэн бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас иргэний шүүхэд хандан нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргасан бөгөөд шүүхээс иргэний хэрэг үүсгэж, тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэр гарсан бол.”

11/37 дугаар зүйлийн 37.9, 37.10 дахь хэсэг:

“37.9. Гадаадын иргэн нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд албадан гаргахаас чөлөөлөгдөнө.

37.10. Энэ хуулийн 37.1.2, 37.1.12-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэн гэр бүлийн болон хувийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, эрүүл мэнд зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүсэлтээ гаргасан тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн албадан гаргахаас чөлөөлөх эсэхийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга шийдвэрлэнэ.”

12/40 дүгээр зүйлийн 40.1.6, 40.1.7 дахь заалт:

“40.1.6. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах;

40.1.7.Монгол Улсад цагаачлан амьдрах зөвшөөрөлтэй гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн гарах-орох зөвшөөрөл олгох;

2 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “орогнох эрх олгоно.” гэсний дараа “Монгол Улсад орогнох эрх олгох үндэслэл, журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.” гэж, мөн зүйлийн 9.2.3 дахь заалтын “Монгол Улсаас албадан гаргах” гэсний дараа “, албадан гаргахаас чөлөөлөх” гэж, мөн зүйлийн 9.3.4 дэх заалтын “хэмжээ тогтоох” гэсний дараа “журам, 40.1.5-д заасан олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “гадаадын иргэний эхнэр, нөхөр,” гэсний дараа “хамтран амьдрагч,” гэж, 37 дугаар зүйлийн гарчгийн “албадан гаргах” гэсний дараа “, албадан гаргахаас чөлөөлөх” гэж, мөн зүйлийн 37.2 дахь хэсгийн “байгууллагын дарга гаргана.” гэсний дараа “Албадан гаргагдсан гадаадын иргэн нь албадан гаргагдсан үндэслэлээс хамааран 1-10 жилийн хугацаанд Монгол Улсад орох эрхгүй байна.” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7.3 дахь заалтын “албадан гаргах” гэсний дараа “, албадан гаргахаас чөлөөлөх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1.11 дэх заалт:

“5.1.11.“Монгол Улсын виз” гэж эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын хилээр нэвтрэх, тодорхой хугацаанд байх зөвшөөрлийг;”

2/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:

“8.1.4.Монгол Улсын үндэсний эв нэгдлийг бусниулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хуульд нийцээгүй бусад аргаар явуулах, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг нийтэд түгээх, сурталчлах, хэрэглэх;”

3/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:

“11.3.Визийг хэвлэмэл хуудас болон цахимаар олгож болно.”

4/15 дугаар зүйл

“15 дугаар зүйл.Визийн ангилал

15.1.Тухайн гадаадын иргэний хилээр нэвтрэх зорилгыг үндэслэн тодорхой ангиллын виз олгоно.

15.2.Визийн ангиллыг энэ хуулийн 9.2.1-д заасан Монгол Улсын виз олгох журмаар тогтооно.”

5/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:

“18.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нэг болон хоёр удаагийн орох виз нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэл 180 хоногийн хугацаанд хүчинтэй байна.”

6/22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт:

“22.1.2.нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн этгээд байвал;”

7/24 дүгээр зүйл:

“24 дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх

24.1 Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.6-д заасны дагуу хил хамгаалах байгууллага нь биеийн давхцахгүй өгөгдлийг авч улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

24.2.Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн огноо, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаар олгоно.

24.3.Гадаадын иргэнийг буудал, орон байр, сууцаар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг оршин сууж буй болон үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно.

24.4.Энэ хуулийн 24.2-т заасан бүртгэлийн дугаар олгохтой холбоотой журам, 24.3-т заасан цахимаар бүртгэх журмыг энэ хуулийн 9.2.2-т заасан Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журмаар зохицуулна.”

4 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн хуулийн 5.1.5 дахь заалтын “Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг” гэснийг “ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээдийг” гэж, мөн зүйлийн 5.1.6 дахь заалтын “Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг” гэснийг “ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээдийг” гэж, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтын “болон” гэснийг “эсхүл,” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “түр ирэгчийн” гэснийг “тухайн визийн” гэж, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “гэр бүлийн гишүүний” гэснийг “хамаарал бүхий этгээдийн” гэж, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “хөдөлмөр эрхлэлт, боловсролын” гэснийг “хөдөлмөр эрхлэлтийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.9 дэх заалтын “захиргааны арга хэмжээ авагдсан” гэснийг “хуульд заасны дагуу хариуцлага хүлээсэн” гэж, мөн зүйлийн 37.5 дахь хэсгийн “паспорт, баримт бичигт Монгол Улсад орохыг хориглосон хугацааг заасан тэмдэглэл хийнэ.” гэснийг “тухай мэдээлэл, Монгол Улсад орохыг хориглосон хугацааг гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд оруулна.” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтын дугаарыг “40.1.8” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “Захиргааны хариуцлагын тухай” гэснийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “30 хоногоос дээш хугацаагаар” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “гарах-орох,” гэснийг, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь хэсгийн “энэ” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 12, 13, 14, 17 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6.30 заалт нэмсүгэй:

“10.6.30.Гадаадын иргэний бүх төрлийн виз, оршин суух зөвшөөрөл олгох талаарх хүсэлтийг хянах үйлчилгээний хураамж 50.000 – 100.000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.6.15, 10.6.16 дахь заалт

“10.6.15.нэг удаагийн орох виз олгоход 115.000 – 270,000 төгрөг;

10.6.16.хоёр удаагийн орох виз олгоход 160.000 – 320.000 төгрөг;”

2/10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг:

“10.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх үйлчилгээ үзүүлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.”

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.3 дахь заалтын “7200-18.000” гэснийг “15.000- 36.000” гэж, мөн зүйлийн 10.6.9 дэх заалтын “1000-2500” гэснийг “10.000-15.000” гэж, мөн зүйлийн 10.6.17 дахь заалтын “126.000 – 315.000” гэснийг “210.000 – 450.000” гэж, мөн зүйлийн 10.6.18 дахь заалт “252.000 – 630.000” гэснийг “460.000 – 750.000” гэж, мөн зүйлийн 10.6.22 дахь заалтын “виз” гэснийг “зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.8, 10.6.12, 10.6.14 дэх заалтын тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг